

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж
ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ
Гүйцэтгэлийн удирдлагын баримт бичиг



**БАЙГУУЛЛАГЫН 2019 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Байгууллагын нэр: Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар

Баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Х.Эрдэнэбилэг/

Тэмдэг

.....
(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Нэгжийн дарга

Захиргаа, санхүүгийн
хэлтсийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Ч.Шинэчимэг/

.....
(огноо)

Нэгтгэж тайлагнасан:
Дотоод хяналт-шинжилгээ,
үнэлгээний ажилтан
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Т.Итгэл/

.....
(огноо)



**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Стратеги төлөвлөгөө & Бодлогын баримт бичиг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ	Дундаж хувь
				100%	100%
1.	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	1	2	100%	100%
2.	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	1	1	100%	100%
Нийт		2	3	100%	100%

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

1.1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Гүйцэтгэлийн зорилт № 1.1.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-17 дахь хэсэг "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна."

№1.1.1.1	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.1-р арга хэмжээ "Иргэдийн оролцоотой - Хөгжлийн жил"-ийн хүрээнд НҮГ нь 2019 оныг "Байгууллагын хөгжил - Үйлчилгээний чанар"-ын жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.3 дахь заалт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1 –р улирал	2-р улирал	3 –р улирал	4 –р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал				
	<i>Суурь түвшин</i>	"Иргэдийн оролцоотой – Амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд НҮГ нь 2018 оныг "Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах жил" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг 100 хувь бүрэн хангаж ажилласан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1 төлөвлөгөө, 1 хэрэгжилт				
	<i>Хүрэх түвшин</i>	Хагас, бүтэн жилд: Төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангасан байна				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	НИТХ болон Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/01 захирамжаар 2019 оныг "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил" болгон зарласны хүрээнд ННҮГ нь "Байгууллагын хөгжил-Үйлчилгээний чанарын жил" болгон зарлаж, тухайн зорилтод жилийн хүрээнд 12 ажил зохион байгуулахаар төлөвлөж, эхний хагас жилийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэн ажилласан.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал				
	<i>Хүрсэн түвшин</i>	Төлөвлөгөө боловсруулж, газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангасан байх				
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%				

№1.1.1.2	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.2-р арга хэмжээ Эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор "Эрүүл ажлын байр"-ны удирдамжийн хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.3 дахь заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Суурь түвшин</i>	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэн ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгох, байгууллага хамт оныхоо дунд эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж 2-р байр эзэлж "Эрүүл ажлын байр"-ыг бүрдүүлсэн шилдэг байгууллагаар өргөмжлөгдсөн.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1 төлөвлөгөө, 1 хэрэгжилт						

	<i>Хүрэх түвшин</i>	Хагас, бүтэн жилд: Төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангасан байна
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>Эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг ажилтан, албан хаагчдад ойртуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эрт илрүүлэгт хамруулах, эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл өгөх зорилгоор “Эрүүл ажлын байр” аяны хүрээнд</p> <ol style="list-style-type: none"> 1. ННҮГ-ын харьяа зоогийн газруудын тогооч, зөөгч, бэлтгэгч, угаач нарыг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ЧДЭМТөвд эрүүл мэндийн шинжилгээнд хамруулж дэвтрийн баталгаажуулалт хийлгүүлж ажилласан. 2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурталчилгааны өдөрлөгийг 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр НИТХ, НЗДТГ, ЧДЭМТ, Оном сантай хамтран НИТХ болон НЗДТГ-ын нийт 141 ажилтан, албан хаагч хамрагдсан. 3. Эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг 2019 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийн багц /цусны дэлгэрэнгүй шинжилгээ, рентген зураг, хэвлийн эхо, зүрхний цахилгаан бичлэг, цусан дах сахар хэмжих, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг/, элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээ, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл өгөх, эрүүл зохистой хооллолтын өдөрлөгийг зохион байгуулж, нийт 250 ажилтан албан хаагчийг хамруулж ажилласан. 4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээгээр “В” вирусын халдвар илрээгүй 70 албан хаагчдаа ХУДЭМН-тэй хамтран “В” вирусын эсрэг сайн дурын 3 шатлалт дархлаажуулах ажлыг зохион байгуулсан. 5. Томуугийн улирал эхэлж байгаатай холбоотойгоор 2019 оны 09 дүгээр сарын 19-нд ДЖБ компанитай хамтран томуугийн эсрэг урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлыг зохион байгуулж нийт 98 ажилтан, албан хаагч тун вакцин хийлгэсэн. 6. НЗЗ-ны байруудад ариутгал халваргүйжүүлэлт, хортон шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн эсрэг ариутгалын ажлыг хавар болон намар жилд 2 удаа зохион байгуулж ажилласан. 7. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэн ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгох, байгууллага хамт оныхоо дунд эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж 2-р байр эзэлж “Эрүүл ажлын байр”-ыг бүрдүүлсэн шилдэг байгууллагаар өргөмжлөгдсөн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал
	<i>Хүрсэн түвшин</i>	Төлөвлөгөө боловсруулж, газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангасан
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%

Гүйцэтгэлийн зорилт № 1.1.2 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-8 дахь хэсэг “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг эрх бүхий байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулах, давтан сургах”

<i>№1.1.2.1</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.2.1-р арга хэмжээ					
	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.6 дахь заалт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Улирал</i>	1 –р улирал	2-р улирал	3 –р улирал	4 –р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал				
	<i>Суурь түвшин</i>	Үндсэн 3 зорилт, 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан. Тайлант хугацаанд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% биелүүлэн ажиллалаа.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	1 төлөвлөгөө, 1 хэрэгжилт				

	<i>Хүрэх түвшин</i>	Хагас, бүтэн жилд: Төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангасан байна
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Манай байгууллага нь үндсэн 3 зорилт, 11 арга хэмжээ бүхий “Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд 2019 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулж батлуулан, төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан. Тайлант хугацаанд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% биелүүлэн ажиллалаа.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал
	<i>Хүрсэн түвшин</i>	Төлөвлөгөө боловсруулж, газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангасан байх
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%



**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Үйлчилгээний төрөл	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ	Дундаж хувь
				100%	
1.	Захиргаа, дотоод ажил	5	6	100%	100%
2.	Байр ашиглалт	3	5	100%	100%
3.	Цэвэрлэгээ үйлчилгээ	1	1	100%	100%
4.	Зоогийн үйлчилгээ	2	5	100%	100%
Нийт		11	17	100%	100%

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

2.1 ЗАХИРГАА, ДОТООД АЖИЛ

Гүйцэтгэлийн зорилт №2.1.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-18 дахь хэсэг "Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг сайжруулна."

№ 2.1.1.1	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.1-р арга хэмжээ Хоол, цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий стандарт, Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээний ерөнхий стандарт, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн ерөнхий стандартуудыг тус тус шинэчлэн боловсруулж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж хэвших							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1 дэх заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Суурь түвшин</i>	-						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Боловсруулсан стандартын тоо						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	"Хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага", "Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээний ерөнхий шаардлага", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага"-аар гарын авлага бэлтгэн, байгууллагын цахим хуудаст байршуулсан ба нийт ажилтан, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшсэн. Ажилтан, албан хаагчдын ур чадвар, үр дүнг үнэлэхдээ дээрх стандартын хэрэгжилтийг ханган ажилласан байдлыг тооцон үнэлгээ өгч ажиллалаа.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Хүрсэн түвшин</i>	3 стандарт боловсруулсан						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%						

Гүйцэтгэлийн зорилт №2.1.2 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-41 дэх хэсэг "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор зорилтот аян, нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллана."

№ 2.1.2.1	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.2.1-р арга хэмжээ "Таныг сонсоё" аян зохион байгуулах							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.7 дахь заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Суурь түвшин</i>	Төрийн албан хаагчдаа сонсож, байгууллагын үйл ажиллагааг дүгнэх үүднээс 2018.11.27-ны өдрөөс 2018.11.30-ны өдрүүдэд "Таныг сонсоё" аянг Нийслэлийн засаг захиргааны 5 байр, нийслэлийн үйлчилгээний 3 төвд зохион байгуулсан. Аяны үеэр нээлттэй саналын хуудсаар болон урьдчилан бэлдсэн саналын хуудсаар нийт 500 орчим албан хаагчаас санал асуулга авсан.						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Зохион байгуулсан аяны тоо, хамрагдсан хүний тоо						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	2019 оны эхний хагас жилд зохион байгуулсан сэтгэл ханамжийн судалгаанд нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч оролцож, байгууллагын үйл ажиллагаанд 64% нь сайн, 28% нь дунд, 8% нь хангалтгүй үнэлгээ өгсөн бол мөн оны сүүлийн хагас жилд зохион байгуулсан "Таныг						
	<i>Хүрэх түвшин</i>	Зохион байгуулсан аяны тоо - 1 Хамрагдсан хүний тоо - 300						

		сонсьё” аянд нийт 683 ажилтан, албан хаагч оролцож байгууллагын үйл ажиллагаанд оролцогчдын 68% нь сайн, 27% дунд, 5% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна. Дүгнэхэд санал асуулгад оролцогчдын сайн үнэлгээ 4%-иар өсч, дунд үнэлгээ 1%, хангалтгүй үнэлгээ 3%-иар тус тус буурсан байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал
	<i>Хүрсэн түвшин</i>	100%
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%

Гүйцэтгэлийн зорилт №2.1.3 Санхүү, бүртгэлийн үйлчилгээг хариуцсан нягтлан бодогч, няраваар дамжуулан иж бүрнээр үзүүлж, анхан шатны ба нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, тайлан тэнцэл гаргах

№ 2.1.3.1	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.3.1-р арга хэмжээ Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, няраваар дамжуулан иж бүрнээр үзүүлэх							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Суурь түвшин</i>	12 агентлаг						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Агентлагийн тоо						
	<i>Хүрэх түвшин</i>	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг иж бүрнээр үзүүлэх						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг 6 агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, 6 агентлаг хариуцсан няраваар дамжуулан ямар нэгэн гомдол саналгүй, иж бүрнээр үзүүлж ажиллалаа.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Хүрсэн түвшин</i>	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг иж бүрнээр үзүүлсэн						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%						

Гүйцэтгэлийн зорилт №2.1.4 Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, нягтлан бодох бүртгэлийг оновчтой зохион байгуулах, санхүүгийн холбоотой мэдээллээр хангах үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

№ 2.1.4.1	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.4.1-р арга хэмжээ Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийг оновчтой зохион байгуулах							
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Суурь түвшин</i>	100%						
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	<i>Хүрэх түвшин</i>	100%						
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Байгууллагад бүртгэлтэй 2567 төрлийн үндсэн хөрөнгө, аж ахуйн материалыг сангийн сайдын баталсан журмын дагуу ажилтан, албан хаагчдад карталж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр нь холбогдох ажилтан, албан хаагчдад шилжүүлэн ажилласан. Тайлант хугацаанд 2 удаа эд хөрөнгийн тооллого хийлээ.						
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	Үйл ажиллагааны зардал						
	<i>Хүрсэн түвшин</i>	Эд хөрөнгийн ашиглалт сайжирсан						
<i>Төсвийн шууд захирагчийн үнэлгээ</i>		100%						

№ 2.1.4.2	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.4.2-р арга хэмжээ Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор газрын даргын тушаалаар тооллогын комисс байгуулж, тооллогыг хагас бүтэн жилээр хийх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагааны зардал						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь Тооллого хийсэн тоо						
	Хүрэх түвшин	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь – 100% Тооллого хийсэн тоо - 1						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Эд хөрөнгийн явцын тооллогыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд 2019 оны 03-сарын 10-ны өдрөөс 20-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэж, бүртгэлтэй болон бүртгэлгүй хөрөнгийн судалгааг гаргаж, тооллогоор зөрүүтэй, бүртгэл нь тодорхойгүй байсан хөрөнгийг тодорхой болгож, НЗДТГ, НИТХ-ын холбогдох албан тушаалтантай эд хөрөнгийн тулгалт хийж, зарим хөрөнгийг НӨАУГ-ын зөвшөөрлөөр бүртгэх ажлыг хийж гүйцэтгэв. Газрын даргын 2019 оны А/40 дүгээр тушаалаар эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг 2019 оны 06-р сарын 06-ны өдрөөс 30-ны өдрүүдэд хийж, актлах эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулав. Тооллогоор нийт 577 нэр төрлийн 14,305,736,744 төгрөгийн үндсэн хөрөнгө, 2241 нэр төрлийн 211,376,224 төгрөгийн аж ахуйн материал тус тус тоологдсон байна. 2019 онд байгууллагын эд хөрөнгөд 2 удаа тооллого хийж, бүртгэлтэй, бүртгэлгүй хөрөнгийг тодорхой болгож, зарим эд хөрөнгийг Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын зөвшөөрлийн дагуу бүртгэсэн. Дээрх тооллогоор актлах эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж ажиллалаа.						
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагааны зардал						
	Хүрсэн түвшин	Үйл ажиллагааг 100% хэрэгжүүлсэн.						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

Гүйцэтгэлийн зорилт №2.1.5 Нийслэлийн засаг захиргааны байруудын дотоод дэг журам, дотор гаднах орчны цэвэрлэгээ үйлчилгээг "Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага" стандартын дагуу хариуцан ажиллах үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

№ 2.1.5.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.5.1-р арга хэмжээ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон төрийн албан хаагчдад чанар стандартад нийцсэн цэвэрлэгээ үйлчилгээг үзүүлэх зорилгоор "Соёлтой үйлчилгээ" болзолт уралдааныг зарлан идэвхжүүлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	71752.1 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	Болзолт уралдааныг амжилттай зохион байгуулсан байх						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Нийслэлийн засаг захиргааны байруудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад үйлчилгээ, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжих, идэвхжүүлэн урамшуулах зорилгоор "Соёлтой үйлчилгээ-Бүтээлч санаа" сэдэвт 1 сарын хугацаатай болзолт уралдааныг зарлан явуулсан. Уралдаанд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 3-н салбарын нийт 14 баг оролцож, НЗЗ-ны 5А байр 1 дүгээр байр, НҮНТ-ийн Дүнжингарав салбар 2 дугаар байр,						

		НЗЗ-ны 5В байр 3 дугаар байр, НЗЗ-ны 2 дугаар байрны БАА-ны баг болон НҮНТ-ийн Драгон салбарын баг тусгай байрыг тус тус эзэлсэн. Уг болзолт уралдаан нь төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр шинэ бүтээл, оновчтой санал гаргаж тухайн байр, орчин нөхцөлдөө амжилттай хэрэгжүүлж нэвтрүүлсэн, санаачилж хийсэн ажил нь өнгө үзэмжтэй, сэргээн засварлах, тохижуулахад өөрсдийн нөөц боломжийг ашиглаж эдийн засгийн хэмнэлт үзүүлсэн үр дүнтэй ажил болсон.
	Зарцуулсан хөрөнгө	71752.1 /Орон нутгийн төсөв/
	Хүрсэн түвшин	Болзолт уралдааныг амжилттай зохион байгуулсан
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

2.2 БАЙР АШИГЛАЛТ

Гүйцэтгэлийн зорилт №2.2.1 Нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн ашиглалтыг хариуцан, инженерийн шугам сүлжээ, ус дулаан, галын аюулгүй байдал болон цахилгаан шат, цахилгааны хэвийн найдвартай ажиллагааг Нийтлэг үйлчилгээний газрын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага" стандартын дагуу хангаж ажиллах үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

№ 2.2.1.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.1-р арга хэмжээ Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байрны дээврийн засварын ажил							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	75000.0 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	-						
	Шалгуур үзүүлэлт	Ажлын гүйцэтгэлийн чанар						
	Хүрэх түвшин	Хагас, бүтэн жилд: 100%						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	НЗЗ-ны 5 дугаар байрны А корпусын 1026 м.кв дээвэр, Б корпусын 1276 м.кв дээврийн засварын ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулж, гэрээ байгуулан, тогтоосон хугацаанд гүйцэтгүүлж, тус ажлыг газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилж, хүлээн авсан.						
	Зарцуулсан хөрөнгө	75000.0 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

№ 2.2.1.2	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.2-р арга хэмжээ Нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн шугам сүлжээ, ус, дулааны найдвартай, жигд ажиллагааг хангаж ажиллах							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	323224.5 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Тайлант хугацаанд мужааны 1476, цахилгааны 960, сантехникийн 1368, операторын 900 нийт 4704 дуудлага хүлээн авч цаг алдалгүй шуурхай гүйцэтгэж ажилласан ба өмнөх онтой харьцуулахад дуудлагын тоо 40%-иар өссөн байна. НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбаруудад урьдчилан сэргийлэх үзлэгийг тус албаны инженерүүд графикайн дагуу 7 хоног бүр, орлогч дарга, албаны дарга нар сар бүр хийж, слесарь, цахилгаанчин, мужаан, лифтчин, техникч, оператор нарт аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай үүрэг даалгавар өгч,						

		шаардлагатай арга хэмжээг тухай бүр нь авч ажиллалаа. Тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын инженерийн байгууламжид ноцтой эвдрэл, гэмтэл гараагүй ба хэвийн ажиллагааг ханган ажилласан.
	Зарцуулсан хөрөнгө	323224.5 /Орон нутгийн төсөв/
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

№ 2.2.1.3	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.3-р арга хэмжээ Нийслэлийн засаг захиргааны байруудын цахилгааны аюулгүй байдлыг бүрэн хангаж, гэмтэл, доголдол гарахаас урьдчилан сэргийлж ажиллах							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	405589.0 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>НЗЗ-ны байруудын цахилгааны аюулгүй байдал, инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж гэмтэл доголдлоос урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг өдөр тутамд тогтмол хийн ажиллаж байна. Тайлант хугацаанд цахилгаан шугам сүлжээний ашиглалттай холбоотой 960 дуудлага ирснийг шуурхай засварлаж ажилласан. Зарим засварын ажлаас дурдвал НЗЗ-ны 3 дугаар байрны 0.4кВтын ерөнхий шитний оруулгын болон давхрын самбарлуу гарсан кабелийн төгсгөвч шатсан байсныг бүрэн шинэчлэн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан.</p> <p>НЗЗ-ны 5-р байранд гадна талын ерөнхий кабель гэмтэж гэмтэлийг засварлахын тулд лабораториор гэмтэлийг тодорхойлсон мөн газар шорооны ажил, холболтын муфьт хийж аюулгүй ажиллагааг хангав. Тус байрны А корпус, Б корпусын хооронд цахилгааны кабель, шит, угсарч цахилгааны ачааллыг бууруулж фазыг тэнцвэржүүлсэн.</p> <p>НҮНТ-ийн "Оргил" салбарын 220 вольтын цахилгаан эрчим хүчийг 380 вольт болгон цахилгаан эрчим хүчийг сайжруулан ажиллалаа.</p> <p>2018 онд нийт 3,464,670 кВтын цахилгаан эрчим хүч зарцуулж байсан бол 2019 онд 3,304,434 кВт-ын эрчим хүч зарцуулсан ба 4%-ийн хэмнэлт үзүүлсэн байна.</p>						
	Зарцуулсан хөрөнгө	405589.0 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

Гүйцэтгэлийн зорилт №2.2.2 Нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн ашиглалтыг хариуцан, инженерийн шугам сүлжээ, ус дулаан, галын аюулгүй байдал болон цахилгаан шат, цахилгааны хэвийн найдвартай ажиллагааг Нийтлэг үйлчилгээний газрын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага" стандартын дагуу хангаж ажиллах үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

№ 2.2.2.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.2.1-р арга хэмжээ Нийслэлийн засаг захиргааны байруудын ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орон зай, орчин бүрдүүлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	35000.0 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	-						
	Шалгуур үзүүлэлт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан засварласан ариун цэврийн өрөөний тоо						
	Хүрэх түвшин	Хагас, бүтэн жилд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан засварласан ариун цэврийн өрөөний тоо – 2 ширхэг						

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Нийслэлийн Засаг захиргааны байруудын ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орон зай, орчин нөхцөлийг бүрдүүлэхээр Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байрны А корпусын ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг тооцсон, стандартын дагуу зориулалтын тоноглол бүхий ариун цэврийн өрөөг тохижуулсан.
	Зарцуулсан хөрөнгө	35000.0 /Орон нутгийн төсөв/
	Хүрсэн түвшин	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан засварласан ариун цэврийн өрөөний тоо – 2 ширхэг
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

Гүйцэтгэлийн зорилт №2.2.3 Нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн ашиглалтыг хариуцан, инженерийн шугам сүлжээ, ус дулаан, галын аюулгүй байдал болон цахилгаан шат, цахилгааны хэвийн найдвартай ажиллагааг Нийтлэг үйлчилгээний газрын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага" стандартын дагуу хангаж ажиллах үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

№ 2.2.3.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.3.1-р арга хэмжээ Хурлын заал, хуралдааны танхимын ашиглалт, үйлчилгээг сайжруулах							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	80702.0 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Хурлын заал, хуралдааны танхимуудын тоног төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Хангарди ордны хурлын А, Б танхимуудад ширээний 26 микрофон, m3060 тикшертэй чадлын өсгөгч 1, таазны чанга яригч 10 төхөөрөмжийг тус тус шинэчлэн суурилуулсан. Мөн дээрхи танхимуудад ханын дуу чимээ тусгаарлагч хавтан (акустик), мөн шаланд хивсэнцэр хавтан хийж тохижуулсан.						
	Зарцуулсан хөрөнгө	80702.0 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

2.3 ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ

Гүйцэтгэлийн зорилт №2.3.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-30 дахь хэсэг "Төрийн зарим үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэдийн үнэлгээний картын систем, үйлчилгээний соёл, стандартыг шинэчлэнэ."

№ 2.3.1.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.1-р арга хэмжээ Төрийн албан хаагчидтай шууд харилцдаг үйлчилгээний болон инженер техникийн ажилтан, албан хаагчдын ажлын чанар, ёс зүйг үнэлж дүгнэхэд "Хяналтын хуудас" болон "Үнэлгээний карт"-ын системийг нэвтрүүлж, хэвшүүлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.9 дэх заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	Үйл ажиллагааны зардал						
	Суурь түвшин	-						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	Хагас, бүтэн жилд: 100%						

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Цэвэрлэгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний болон инженер техникийн ажилтан, албан хаагчдын өдөр тутмын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Хяналтын хуудас”, “Үнэлгээний карт”-ын системийг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар тэдгээрийн загвар болон хэрэгжүүлэх хугацааг хэлэлцэн шийдвэрлэж, 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна.
	Зарцуулсан хөрөнгө	Үйл ажиллагааны зардал
	Хүрсэн түвшин	100%
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%

2.4 ЗООГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Гүйцэтгэлийн зорилт №2.4.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-51 дэх хэсэг "Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулна"

№ 2.4.1.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.1.1-р арга хэмжээ Үндэсний их баяр наадмын үйлчилгээний бэлтгэл ажлыг ханган оролцох							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5 дахь заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	154635.9 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	18 оны тайлангаас						
	Шалгуур үзүүлэлт	Хийгдэх ажлын тоо, гүйцэтгэсэн ажилчдын тоо,						
	Хүрэх түвшин	Хагас, бүтэн жилд: Наадмын бэлтгэл ажил хангаж, үйлчилгээ бүрэн үзүүлсэн байна.						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 104 ажилтан, албан хаагчид Үндэсний их баяр наадмын арга хэмжээний үеэр Хүй 7 худаг, Төв цэнгэлдэх хүрээлэн, уяачдын наадмын төв асарт үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай 10, 8, 5 ханатай гэрүүд, гал тогооны зөөврийн сууцыг байршуулах, зөөвөрлөх зэрэг баяр наадмын бэлтгэл ажлыг хангаж, 07 дугаар сарын 11-13-ны баярын өдрүүдэд 300 гаруй зочид, төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барьж, хүлээн авалтын үйлчилгээг үзүүлэн ажилласан. Мөн нийслэл хот үүсэн байгуулагдсаны түүхт 380 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн удирдлагууд Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт байрлах нийслэлийн анхны шавыг тавьсан гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний үеэр 50 гаруй ажилтан, албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр орон нутгийн удирдлагууд болон хүрэлцэн ирсэн зочид, нутгийн иргэдэд хүндэтгэлийн хүлээн авалтын үйлчилгээг амжилттай зохион байгуулан ажилласан байна.						
	Зарцуулсан хөрөнгө	154635.9 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	104 албан хаагч ажиллаж, наадмын бэлтгэл ажлыг хангаж, үйлчилгээг бүрэн үзүүлсэн						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

№ 2.4.1.2	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.1.2-р арга хэмжээ Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах арга хэмжээний үйлчилгээний бэлтгэл ажлыг ханган оролцох							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5 дахь заалт						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	154635.9 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						

Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах арга хэмжээнүүдийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>Хурлын танхимын үйлчилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд НИТХ-ын ээлжит болон ээлжит бус чуулган 18, НЗД-ын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 18, НЗД-ын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурал 21, ЗАА-ны шуурхай зөвлөгөөн 22, шагнал гардуулах үйл ажиллагаа 31, бусад харъяа байгууллагуудын хурал, зөвлөгөөн, семинар, сургалт 556 удаа нийт 689 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж, үйл ажиллагаанд хамрагдсан 11120 хүнд үйлчилсэн байна. Үүнээс 41 удаагийн үйл ажиллагаанд цай завсарлагын үйлчилгээг үзүүлжээ.</p> <p>Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Хүндэтгэлийн хүлээн авалт 96 удаа - 5496 хүнд; - Катерингийн үйлчилгээ 13 удаа – 4115 хүнд; - VIP үйлчилгээ 8 удаа - 560 хүнд; - Хурлын цайны завсарлага 41 удаа – 6189 хүнд; - Өглөөний цай үйлчилгээ 150 удаа – 3800 хүнд тус тус үйлчилгээ үзүүлж, нийт 308 удаагийн үйлчилгээгээр 20,160 хүнд зоогийн үйлчилгээ үзүүлсэн байна. <p>Нийтийн хоолны үйлчилгээний чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Хангарди ордоны зоогийн газар өдөрт дунджаар 200-300 хүнд, жилд дунджаар 52,800 хүнд; - НЗДТГ-ын цайны газар өдөрт дунджаар 160 орчим хүн, жилд дунджаар 42,240 хүнд; - НЗЗ-ны 5-р байрны зоогийн газар 150 орчим хүн жилд дунджаар 39,600 орчим хүн, өдрийн зоогийн үйлчилгээг давхардсан тоогоор нийт 134,640 хүнд тус тус үйлчилсэн байна. <p>Зоогийн үйлчилгээний хүртээмж өмнөх онтой харьцуулахад 49,7%-иар нэмэгдэж, орлого төвлөрүүлэлт 58,8%-иар өссөн байна.</p>						
	Зарцуулсан хөрөнгө	154635.9 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

Гүйцэтгэлийн зорилт №2.4.2 Эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээг төрийн албан хаагчдад цаг тухайд нь үзүүлж, "Хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" стандартыг ханган ажиллах үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

№ 2.4.2.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.2.1-р арга хэмжээ							
	Хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, хээрийн үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	185563.1 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Тайлант хугацаанд хүлээн авалтыг 142 удаа 7518 хүнд, цай завсарлагыг 79 удаа 10604 хүнд, катеринг үйлчилгээг 18 удаа 9665 хүнд, VIP үйлчилгээг 16 удаа 830 хүнд, өглөөний цайны үйлчилгээг өдөр бүр 10-15 хүнд буюу 3800 орчим хүнд тус тус үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Зоогийн үйлчилгээний хүртээмж өмнөх онтой харьцуулахад 49,7%-иар нэмэгдэж, орлого төвлөрүүлэлт 58,8%-иар өссөн байна.						
	Зарцуулсан хөрөнгө	185563.1 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

№ 2.4.2.2	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
-----------	--	--	--	--	--	--	--	--

Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.2.1-р арга хэмжээ Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд Хүндэтгэлийн хүлээн авалтын шилэн эдлэлийг "БРЭНД БҮҮК"-ийн дагуу иж бүрнээр шинэчлэн үйлчилгээнд нэвтрүүлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	28400.0 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	-						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойг угтан нийслэлээс зохион байгуулагдаж буй хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээнүүдэд хэрэглэгдэх, нийслэлийн өнгө төрхийг илэрхийлсэн лого бүхий шаазан эдлэлд тавигдах ерөнхий шаардлага, стандартыг боловсруулж, стандартын дагуу шаазан эдлэлүүд үйлчилгээнд нэвтрүүлсэн. "Брэнд Бүүк"-ийн дагуу бэлтгэсэн шаазан эдлэлүүдийг Улсын баяр наадмын төрийн хүндэтгэлийн хүлээн авалтад мөн нийслэлийн 380 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан нийслэлийн анхны шавыг тавьсан газар буюу Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Ширээт цагаан нуурын хөвөөнд орших Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээний үеэр Нийслэлийн удирдлагууд болон гадаад, дотоодын зочдод үзүүлэх хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээнүүдийн үйлчилгээнд бүрэн хэрэглэж байна.						
	Зарцуулсан хөрөнгө	28400.0 /Орон нутгийн төсөв/						
	Хүрсэн түвшин	100%						
Төсвийн шууд захирагчийн үнэлгээ		100%						

№ 2.4.2.3	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин							
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.4.2.3-р арга хэмжээ Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, кофе шоп болон хээрийн үйлчилгээнд хэрэглэгдэх сав баглаа боодлыг "Брэнд бүүк"-н дагуу иж бүрнээр шинэчлэн, амт чанартай эрүүл хоолоор үйлчлэх							
	Төлөвлөлтийн уялдаа:	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамж						
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Сар	1 / 7	2 / 8	3 / 9	4 / 10	5 / 11	6 / 12
	Шаардагдах хөрөнгө	278344.7 /Орон нутгийн төсөв/						
	Суурь түвшин	100%						
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь						
	Хүрэх түвшин	100%						
